



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/566

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн Зургаадугаар хуралдааны “Аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоолын 05 дугаар хавсралтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны хуучин байрны засварын ажилд 10,000,000.0 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012545